



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/228

Улаанбаатар хот


**Сонгинохайрхан дүүргийн Эрүүл
мэндийн төвийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 213,000,000.0 /хоёр зуун арван гурван сая/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв /Ж.Болортуяа/-д зөвшөөрсүгэй.


2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв /Ж.Болортуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 09 өдрийн 1/228 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт хүчин чадал	Ашиглалтад орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Эхо аппарат дижитал	HI vision avius	4D	2017	сайн	ш	1	213,000,000.0	213,000,000.0	Япон улсын засгийн газар	хандив
Нийт дүн									213,000,000.00		